МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,107.077... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.09.26. Даваа. №170 (4540) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

Д.ГАНБАТ: ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ 2019 ОНД АШИГЛАЛТАД ОРНО

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

БАРИВЧИЛГАА, ШАЛГАЛТ ҮРГЭЛЖИЛСЭЭР...

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Хөдөөний замд шалгалтаа хийгээч

Э.ТУУЛ

Замын цагдаагийн газар, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран улсын хэмжээнд явж буй автомашинууд стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг өнгөрөгч наймдугаар сарын 29-ний өдрөөс шалгаж эхэлсэн. Энэхүү шалгалт энэ сарын 30-ны өдрийг хүртэл үргэлжлэх бөгөөд автомашины өнгө үзэмж, бүрэн бүтэн байдал, салхины шил цуурсан эсэх, машины улсын дугаар бүдгэрсэн, гэрэл дохио, цацруулагч, ослын гурвалжин, эмийн сан, гал унтраагч гэх мэт зүйлсийг нарийвчлан шалгаж буй. Түүнээс гадна бензин хөдөлгүүртэй машинаас гарч буй утаан дахь хорт бодисын хэмжээ, дизель хөдөлгүүртэй машины утаан дахь тортогжилтыг хэмжиж, жолооч нарт 19200-аас эхлээд 42 мянган төгрөг хүртэл торгууль ногдуулж байгаа.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ




Н.ПУНЦАГБОЛД

Гадаад оронд, татваргүй бүсэд хамаг мөнгөө аваачиж нуудаг жишиг Монголын баячууд, томчуудыг ч тойроогүй. Яг үнэндээ монголчууд бид тийм зүйл байдаг гэдгийг мэдээгүй л байсан. Харин нэг нөхөр оффшор бүсэд сая ам.доллараа мартсаны гайгаар иргэдэд мэдэгдэлгүй дарж байсан нууц бүхэн илрэхгүй юу. Гэхдээ л нэг хэсэг оффшор данс, татваргүй бүсэд мөнгөө нуух гэдгийг ганцхан хүнээр төсөөлж байсан нь үнэн. Гэтэл сая сонгуулийн өмнө АНУ-ын Вашингтон хот дахь Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлзүйн консорциумаас Панамын арлууд дахь оффшор компаниудын эзэдтэй холбоотой 2.5 сая баримтыг дэлхий нийтэд ил болгосон. Энэ дүйвээнээр Монголын маш олон улстөрч, бизнесмэнүүд оффшор бүсэд данстай, мөнгө төгрөгөө нуудаг нь илэрч, ард түмнийг сэхээрүүлэв. Хамгийн сүүлд гэхэд Монгол Улсын Засгийн газрын тэргүүнээр ажиллаж байсан хүний нэр энэ асуудалтай холбогдлоо. Мөн цөөнгүй хүн энэ талаараа янз бүрийн тайлбар хийж, өөрсдийгөө өмөөрөөд байгаа. За тэр өмөөрөх, өмөөрөхгүй нь ч дүүрч. Ер нь бол Монголын төрийнхөн, том баячууд дунд оффшор дансгүй, татваргүй бүсэд тэрбумаар нь мөнгө нуугаагүй хүн байхгүй гэж яриад байгаа нь үнэн л болж таарах гээд байна. Тийм болохоор эрхэм эрх баригч, эрхтэн дархтан, эд мөнгөтөнгүүд минь ээ, оффшор бүсэд байгаа мөнгөө эх орондоо авч ирэх арга чарга хайсан нь дээр юм биш үү.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ОНЦЛОХ МЭДЭЭ

## Монголын шигшээ баг Азийн аварга боллоо

Н.ПУНЦАГБОЛД

Азийн оюутны аварга шалгаруулах сагсан бөмбөгийн зургаа дахь удаагийн тэмцээнд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо болж өндөрлөлөө. Энэ удаагийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд Хятад, Тайвань, Монгол, Хонконг, БНСУ тэргүүтэй долоон баг оролцсон юм. Тэгвэл Монгол Улсын оюутны шигшээ баг түүхэн амжилт үзүүлж, анх удаа Азийн аварга боллоо.

Манай шигшээ баг финалд Тайваньтай тулж, 92:79-өөр буулгаж авснаар аварга болсон юм. Тэгвэл хүрэл медалийн төлөө Хятад болон Хонконгийн баг тоглож, 92:82-оор өмнөд хөршийн шигшээ хожлоо.

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

## М.ИЧИННОРОВ: Төрийн цагдаа хохирогчийн өмгөөлөгчийн байр сууринд ажиллах ёстой

–Энэ бол хэн нэгний имиж, чимэг болоод явах ёстой асуудал биш–

Ж.МЯГМАР

*Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг эргүүлэн татаж, багц хуулийн төслөөс салган намрын чуулганаар хэлэлцүүлэхээр тогтсон билээ. Тэгвэл энэ асуудлын хүрээнд Хүний эрхийн хуульч М.Ичинноровтой ярилцлаа.*

**-УИХ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг эргүүлэн татсан, мөн Эрүү, зөрчлийн хуулийг хойшлуулж, холбогдох багц хуулиудыг буцаалаа. Үүнийг зарим улс төрийн хүчин мөн хүний эрхийн төлөө тэмцэгчид маш том ухралт гэж харж байна. Таны хувьд үүнийг юу гэж үзэж байна вэ, шалтгаан нөхцөл нь юу юм бол?**

-Шулуухан хэлэхэд, хүний эрхийг дордуулсан алхмуудыг хийж байна. Энэ нь эрх зүйн үндсэн зарчмыг зөрчсөн бөгөөд Үндсэн хууль зөрчсөн үйлдлүүд юм. Мөн энэ улстөрчид, тэдний хань хамсаатнууд, ойр дотныхны дунд хүчирхийлэл үйлдэгчид олон байдаг тухай сонсогддог. Тэд ч өөрсдөө төрийн хяналтын гадуур байхыг хүсдэг биз. Нөгөөтэйгүүр тэдэнд хүний эрхийн талаар мэдлэгтэй, мэдрэмжтэй, сэтгэлтэй хүн байхгүй нь ингээд батлагдлаа. Хүний эрхийн боловсрол бол маш том боловсрол бөгөөд тухайн улстөрчийн болон улс төрийн институцийн соёлыг илтгэдэг.

**Үргэлжлэл нь IV нүүрт**

## АЛБАН ШААРДЛАГА

**2016.09.23** **Улаанбаатар хот**

УИХ-ын 2016 оны сонгуульд МАН 65 суудал авснаар Монгол Улсын төрд нэг намын дарангуйлал тогтов. МАН Засгийн газар байгуулсан өдрөөсөө эхлэн Ардчилсан намын эрх барьж байх үед хийж бүтээсэн бүгдийг үгүйсгэн харлуулах, Ардчилсан намын гишүүдийг гэмт хэрэгт холбон шалгах аргаар айлган дарамтлах, тэдэнд ямар нэгэн бурууг олж тохох, ардчилсан үзэлтэй төрийн албан хаагчдыг төрийн албанаас хоморголон халах ажиллагааг зохион байгуулалттай өрнүүлж байна.

Цагдаагийн болон бусад хүчний байгууллагыг ашиглан Ардчилсан намын удирдлага, ҮЗХ-ны гишүүдэд зохиомол эрүүгийн хэрэг үүсгэж, заримыг нь шоронд хорьж байгаа нь орон нутгийн сонгуульд нөлөөлөх, ардчиллыг нухчин дарах, коммунист дэглэмийг сэргээх улс төрийн зорилготой үйлдэл гэж Ардчилсан нам үзэж байна.

Эрх баригчид орон нутгийн сонгуульд зориулан Ардчилсан намын нэр хүндийг гутааж, элдэв гүтгэлэг хийж, Ардчилсан намын гишүүдэд эрүүгийн хэрэг үүсгэж хэлмэгдүүлэлт явуулж байгааг Ардчилсан нам эрс эсэргүүцэж байна.

Улс төрийн зорилготой хэлмэгдүүлэлтийн үйл ажиллагаагаа нэн даруй зогсоохыг МАН-ын дарга, УИХ-ын дарга М.Энхболд танаас шаардаж байна.

Ардчилсан нам улс төрийн хэлмэгдүүлэлтийн эсрэг тууштай, эрс хатуу тэмцэх болно.

**АРДЧИЛСАН НАМЫН ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛ**

“ШИНЭ ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГТ ТАВТАЙ МОРИЛ

Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.

Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.



ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО

Холбоо барих утас: 99094864

| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2255.00 | 2268.00 | ФУНТ | 2890.00 | 2992.00 | АМ.ДОЛЛАР | 2254.00 | 2268.00 | ФУНТ | 2880.00 | 3010.00 |
| ЕВРО | 2492.00 | 2562.00 | РУБЛЬ | 33.90 | 36.90 | ЕВРО | 2483.00 | 2596.00 | РУБЛЬ | 33.26 | 38.68 |
| ИЕН | 22.04 | 22.66 | ЮАНЬ | 337.00 | 340.80 | ИЕН | 21.87 | 23.04 | ЮАНЬ | 336.50 | 340.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Сангийн яамны ТНБД-ын сонгон шалгаруулалтыг зарлалаа

Засгийн газрын лхагва гарагийн хуралдаанаар зарим яамны төрийн нарийн бичгийн дарга нар томилогдсон. Тодруулбал, энэ сарын 12-нд болсон төрийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалт тэнцсэн Г.Баясгаланг Хууль зүй, дотоод хэргийн яамны, Д.Даваасүрэнг Гадаад харилцааны яамны, Г.Өнөрбаярыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны, Г.Нандинжаргалыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны, Л.Баяртулгыг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар тус тус томилсон. Тэгвэл Төрийн албаны зөвлөлд Сангийн яамны сонгон шалгаруулалт явуулах захиалгийг Засгийн газраас хүргүүлжээ. Сонгон шалгарлуулалт оролцох хүсэлтэй иргэдийн материалыг ирэх сарын 17-ны өдрийн 09.00-12.00, 13.00-17.00 цагийн хооронд хүлээн авах ажээ. Харин шалгарлуулалт нь ирэх сарын 18 өдөр болох юм байна. Мөн энэ сарын 29-нд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын ажлын байранд өрсөлдөхөөр бүртгүүлж буй иргэдээс шалгалт авахаар төлөвлөөд байгаа ажээ.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ТОМИЛОЛТ



# Д.ГАНБАТ: ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ 2019 ОНД АШИГЛАЛТАД ОРНО

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат энэ сарын 22-24-ний өдрүүдэд Дундговь, Өмнөговь аймагт ажиллаж, нутгийн удирдлагууд болон иргэд хөдөлмөрчидтэй уулзлаа. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ болон Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого, Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого, Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр зэрэг хөгжлийн баримт бичгүүдийг танилцуулсан юм. Тэрбээр Дундговь, Өмнөговь аймгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг Засгийн газрын бодлоготой уялдуулах зорилгоор ийнхүү томилолтоор ажилласан байна. Дундговь аймаг нь Улаанбаатар хотоос 280 км-ийн зайд оршдог. Өнгөрсөн оны байдлаар 2.7 сая толгой мал тоолуулсан бөгөөд хүнсний ногоо 44 га талбайд тариалж буй гэх мэт мэдээллүүдийг тус аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ өглөө. Авто замын хувьд аймгийн төв болон Дэлгэрцогт, Луус, Хулд гэсэн сумд Даланзадгад-Улаанбаатарыг холбосон хатуу хучилттай замтай холбогддог. Орон нутагт 15.2 км хатуу хучилттай замтай бөгөөд Улаанбаатар-Мандалговь чиглэлд өдөрт хоёр удаа том оврын автобус зорчигч, тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа талаар танилцуулав.

Засаг дарга О.Бат-Эрдэнэ уулзалтын үеэр улс орны эдийн засгийн нөхцөл хүнд байгаатай адил өмнөх Засаг дарга сар бүр арав гаруй сая төгрөг зарцуулж, найм болон есдүгээр сарын хөрөнгийг ашигласнаар Засаг даргын нөөц хөрөнгө дууссан талаар сайдад уламжиллаа. Тэрбээр мөнгөгүй гээд гар хумхиж суулгүй гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийг идэвхижүүлэх тал дээр анхаарал хандуулан ажиллаж байгаа талаар мэдээлэл өгөв. Мөн Засгийн газрын өргөтгөсөн хуралдаан дээр Арвайхээр-Мандалговь-Говьсүмбэр- Сайншанд чиглэлийн хөндлөн чиглэлийн авто замыг тавиулах зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа тул шийдүүлж өгөхийг хүсэв. Ингэснээр босоо чиглэлийн авто замын ачаалал багасч, эдийн засгийн хувьд хэмнэлт гарах ач холбогдолтой тул ТЭЗҮ хийгээд өгчихвөл хөрөнгө оруулалт хийгдэх боломжийг судлахаа илэрхийллээ.

Зам, тээврийн хөгжлийн сайд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бүх аймгийг хатуу хучилттай авто замаар холбох зорилтын дагуу одоо зургаан аймгийг холбох ажил үлдсэн талаар онцоллоо. Авто зам барихдаа үрэлгэн байдлаар хандалгүй, зөв шийдлээр хөрөнгө босгож, хаана ямар замыг, хэрхэн барих, ачаа зорчигч тээврийн асуудал зэргийг нарийн тооцоолох хэрэгтэйг хэлсэн юм.

Сайд Д.Ганбат иргэд хөдөлмөрчидтэй уулзах үеэр тэдний асуултад хариулж, санал бодлыг нь сонслоо. Уул уурхайн ашигт малтмалыг хэрхэн зөв замаар ашиглаж, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх тал дээр шинэ Засгийн газраас ямар бодлого баримталж байгаа талаар орон нутгийн иргэд ихээхэн ач холбогдол өгч байлаа. Тухайлбал, улс орны эдийн засагт өндөр ач холбогдолтой Оюу толгой, Тавантолгой,

> ...Авто зам барихдаа үрэлгэн байдлаар хандалгүй, зөв шийдлээр хөрөнгө босгож, хаана ямар замыг, хэрхэн барих, ачаа зорчигч тээврийн асуудал зэргийг нарийн тооцоолох хэрэгтэйг хэлсэн юм...

Эрдэнэт үйлдвэрийн томоохон үйлдвэр, төслүүд хэзээ үр ашгаа өгөх талаар иргэд асуулт асууж, санал бодлоо илэрхийллээ. Мөн Тавантолгойн цахилгаан станц хэзээ баригдаж ашиглалтад орох, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ашиглалтад оруулах асуудал Мэргэжлийн Засгийн газрын зорилтод байгаа эсэх талаар ихээхэн сонирхож байв. Салбарын сайд 2019 он гэхэд тус төмөр зам бүрэн ашиглалтад орж, тээвэрлэлтээ эхлүүлэх боломжтой талаар иргэдэд мэдээллээ.

Сайд Д.Ганбат орон нутагт ажиллах үеэрээ уул уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагааны зохион байгуулалттай танилцаж, тулгараад буй саад бэрхшээлийг арилгах талаар судлах зорилгоор Өмнөговь аймагт ажилласан. Тэрбээр Эрдэнэс Тавантолгой компанийн удирдлагуудтай уулзаж, уурхайн үйл ажиллагаатай танилцлаа. Мөн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн автозамын нөхцөл байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагаа, боомтын нөхцөл байдалтай танилцаж, тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллахаар болов.

Тус чиглэлийн замын ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа хангалтгүй түвшинд байгаа тул харилцан уялдаа холбоотойгоор зохион байгуулалтыг сайжруулж, тээвэрлэлтийг боловсронгуй болгох тал дээр цогц арга хэмжээ авах шаардлагатай байгааг онцоллоо. Мөн Гашуунсухайт боомтод тулгараад буй олон асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх шаардлага гарсан байгааг хэлж байв. Тэрбээр боомтын удирдлагууд болон тээвэрлэгч аж ахуй нэгжийн төлөөлөлтэй уулзаж, тэдний саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлэхээ амласан юм. Салбарын сайдыг Гашуунсухайт боомтод ажиллах үеэр нүүрс тээвэрлэлтийн том оврын машинуудын дараалал тус боомтоос Цагаанхад хүртэл 20 орчим километрийн цуваа үүсгэсэн байлаа. Энэ нь боомтын нэвтрүүлэх хүчин чадал, хяналтын системээс гадна БНХАУ-ын хилийн боомтод үүсээд буй ачаалалтай холбоотойг албаныхан хэлж байв. Үүнийг шат дараатайгаар шийдвэрлэж, нэгдсэн хяналтын системтэй болгож, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулахад анхаарч ажиллахаар боллоо.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Чоннам, Чосан их сургуулиудын эмч нартай хамтран ажиллахаар болов

УИХ-ын дарга Миеэгомбын Энхболд БНСУ-ын Гванжу хотын дарга Юн Жанг Хюүн тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд УИХ-ын дарга М.Энхболд БНСУ-ын Гванжу хотын дарга Юн Жанг Хюүнтэй уулзсандаа баяртай байгаагаа хэлээд Гванжу болон Улаанбаатар хотын харилцааг хөгжүүлэх чухал айлчлал хийж байгаад талархал илэрхийлэв. Мөн тэрбээр "Хоёр улсын харилцаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж төр засгийн байгууллага хооронд төдийгүй худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол зэрэг өргөн цар хүрээнд өргөжиж байгаад сэтгэл хангалуун байдаг. Манай хоёр орны төр засгийн удирлагуудын өндөр дээд хэмжээний харилцан айлчлал тогтмолжиж байна. Сар гаруйн өмнө БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ манай улсад албан ёсны айлчлал хийсэн. Энэ үеэр бид хоёр орны хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар харилцан санал солилцсон. Манай хоёр хотын хамтын ажиллагаа эхэлж байгаад баяртай байна. Одоогоос 17 жилийн өмнө Улаанбаатар хотын Засаг даргаар ажиллаж байх үедээ Сөүл, Улаанбаатар хотуудыг ах дүүгийн харилцаатай болгож байсан" хэмээгээд зөвхөн төр засгийн төдийгүй орон нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал болохыг цохон тэмдэглэв. БНСУ-ын Гванжу хотын дарга Юн Жанг Хюүн УИХ-ын даргыг цаг гарган хүлээн авч уулзаж буйд нь талархал илэрхийлээд Улаанбаатар хоттой эрүүл мэнд, боловсролын салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй байгаагаа сонордуулсан юм. Түүнчлэн тус хотын Чоннам, Чосан их сургуулиудын эмч нар Монголын эрүүл мэндийн байгууллагуудтай зүрх судас, эмэгтэйчүүдийн мэс заслын чиглэлээр хамтран ажиллахаар болсон байна. БНСУ-ын Гванжу хот нь 1.5 сая хүн амтай, тус улсын соёл, спортын томоохон төвд тооцогддог байна. Тиймээс энэ чиглэлд хоёр хотын хамтын ажиллагааг эхлүүлэх боломжийн талаар талууд уулзалтын үеэр ярилцлаа.

## Ерөнхийлөгч Бан Ги Мүнтэй уулзлаа

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 71 дүгээр чуулганы хүрээнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүнтэй уулзлаа. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн НҮБ-ын төдийгүй олонулсын томоохон арга хэмжээ, энхийн болоод дэлхий дахины хөгжил цэцэглэлтийн төлөө үйлсэд идэвхтэй оролцсоор ирсэн Монгол Улсын хүчин зүтгэлийг өндрөөр үнэлэн талархаж буйгаа илэрхийллээ. Тэрбээр НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжин улс орондоо хэрэгжүүлээд байгаагаас гадна "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр"-ийг батламжилсан Монгол Улсад баяр хүргэв. Мөн НҮБ-ын энхийг сахиулах үйлсэд хувь нэмрээ өнөө хэр нь оруулсаар байгаа Монголын ард түмэнд талархлаа илэрхийлсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгч олон улсын арга хэмжээнд оролцон, дэлхий дахинаа тулгамдаж буй сорилт бэрхшээлийг хамтдаа хэлэлцэн, Тогтвортой хөгжлийн зорилтууд, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр гэх мэт хамтын шийдвэрийг хэрэгжүүлэх нь Монгол Улсын хувьд чухал үүрэг хэмээгээд энэ чиглэлд цаашид тууштай ажиллахаа мэдэгдэв. Уулзалтын үеэр талууд НҮБ болон олон улсын хамтын ажиллагаан дахь Монголын үүрэг оролцоог нэмэгдүүлэх талаар болон дэлхий нийтэд тулгамдаад буй зарим асуудлын талаар ярилцжээ. Дараа нь Монгол Улсын Ерөнхийлөгч НҮБ дэх Байнгын төлөөлөгчийн газарт зочлон, Нью-Йорк хотноо ажиллаж амьдардаг монгол иргэдийн төлөөлөлтэй уулзсан байна.

## Ерөнхийлөгчийн хүү орон нутгийн сонгуульд өрсөлдөнө

Энэ удаагийн орон нутгийн сонгуульд олон сонирхолтой нэр дэвшигчид өрсөлдөхөөр болсны нэг нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хоёр дахь хүү Эрдэнэ юм. Тэрбээр Баянзүрх дүүргийн 27 дугаар хороонд Ардчилсан намаас нэр дэвшин өрсөлдөхөөр болж, сонгуулийн бэлтгэл ажилдаа оржээ.




Э.Эрдэнэ 2007 онд Улаанбаатар хотноо ерөнхий боловсролын дунд сургуулийг, 2011 онд АНУ-ын Дрекселийн их сургуулийг биохимич мэргэжлээр төгссөн бол 2015 онд Оксфордын их сургуулийн Улс төрийн сургуульд улс төр судлаач-нийтийн удирдлага мэргэжлээр суралцан магистрийн зэрэг хамгаалсан байна. Энэ оны дэлхийн шилдэг их сургуулиудын нэгдүгээрт эрэмблэгдэж буй тус сургуулийн анхны монгол оюутан байсан төдийгүй шилдэг арван оюутны нэгээр шалгарч Их Британийн хан хүү Уильямтай уулзах эрхээр "шагнуулж" явсан тухайгаа нүүр номондоо бичсэн нь бий.

Эзэмшсэн мэргэжлээрээ Цэргийн клиникийн төв госпитальд лабораторийн эмчээр нэг жил орчим ажиллаад улстөрчдийн хүүхдүүд тэр бүр сонирхоод байдаггүй офицерын дамжааг дүүргэн Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад энхийг сахиулахаар мордож байсан аж.

Ямартай ерөнхийлөгчийн хүү улс төрийн гараагаа анхан шатны сонгуулийн хорооноос эхэлж байна.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

# ÎÔÔØÎÐ×ÄÛÃ ӨРШӨӨЛД ХАМРУУЛЪЯ



**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Болохгүй бол оффшор бүсэд хадгалсан мөнгөө үнэнчээр мэдэгдээд, оруулж ирсэн хүмүүсийг өршөөлд хамруулъя л даа. Тэрийг нь заавал олон нийтэд мэдэгдэх хэрэг юун. Дуугүй л дээгүүрээ тохиролцоод, зөвшилцөөд л оруулаад ирчихээч дээ. Айлаас ирэхээр авдраа уудал гэдэг дээ. Эдийн засаг хямарсан, өсөлт нь зогсоод, дифлаци болж эхэлж байгаа энэ үед жаахан ёс суртахуунтай байж яагаад болохгүй гэж. МАН-ынхан татвар нэмнэ, бүгдийг хасна, танана гэж байхаар оффшор бүсэд байгаа их мөнгийг л Монголд оруулж ирэх арга бодож олох хэрэгтэй. Магадгүй тэр нь өршөөл байж яагаад болохгүй гэж. Энэ чинь, эх орноо өөд нь татаж, эдийн засгаа тэлж, өсгөж л байвал хэдэн хүнийг өршөөгөөд, мөнгийг нь эргэлдүүлэхэд болохгүй юм юу байна. Манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн бичээд байгаагаар бол оффшор бүсэд Монголын баячууд 10 тэрбум ам.доллар аваачаад нуучихсан юм гэсэн. Зарим нь үүнээс ч өндөр тоо хэлээд байна. Хэрвээ энэ үнэн бол өнөөх “Чингис” бондын 1.5 тэрбум ам.доллар энэ тэр чинь багахан сонсогдож байгаа биз дээ. Тийм болохоор гаднаас өөр орлуулах бонд хайж, өмнөх өрөө төлж, хугацааг нь уртасгах гэж байхаар өөрсдийнхөө хүмүүсээс зээлчихсэн ч болно. Манай төрийн томчууд бол бүх мэдээллийг л авч байгаа нь тодорхой. Магадгүй хэн хэн оффшор бүсэд, хэчнээн ам.доллар нуусныг ч мэдэж байгаа биз. Тиймээс УИХ-ын дарга, Ерөнхий сайдаасаа эхлээд

...“Шинэчлэлийн”, “Шийдлийн” Засгийн газрын үед Путины энэ ажлаас санаа аваад хийж чадаагүй. Хүчрээгүй юм байлгүй дээ. Тэгвэл одоо яагаад эхэлж болохгүй гэж. Оройтоогүй шүү дээ. Оффшор бүсэд мөнгөө хадгалуулна гэдэг бол тийм ч бузар булай юм биш л дээ. Бизнесмэнүүд арай гэж хэдэн төгрөгийн ашиг олдог. Тэрийг нь татвар нэрээр төр хуу хамаад авчихдаг...

эрх баригчид хэлэлцэж байгаад өөрсдийнхөө оффшор дансанд мөнгөө нуусан хүмүүсээс зээлээд авчих хэрэгтэй. Засгийн газар хэдэн тэрбум ам.долларын өртэй байгаа билээ.

Тэр хэмжээний мөнгөө өөрсдийнхөө нөхдүүдээс маш бага хувийн хүүтэй зээлж аваад л гүйцээ. Иргэдэд тайлбарлахдаа юу ч гэсэн ядаг юм. Манайхан идэх хоолтой л бол элдэв зүйл нэхэж мэддэггүй хүмүүс. Ийм маягаар өршөөл үзүүлж бас болно шүү дээ. Тэр мөнгө нь алга болохгүй. Төр эргүүлээд төлчихнө. Хэзээ миний оффшор дансан дахь мөнгө илрэх бол гэж өдрийн бодол шөнийн зүүд болж суусанаас л дээр, нөгөө хүмүүст. Эсвэл Оросын жишгийг дагаад, оффшор бүсэд байгаа Монголын бүх мөнгийг авч ирэх арга хайж яагаад болдоггүй юм бэ. Ер нь манайх зарим нэг сайн жишгүүдийг ашиглах л хэрэгтэй. Путин яасан билээ. Оффшор бүсэд мөнгөө нуусан бизнесмэнүүдийг өршөө гэж хэлээ биз дээ. Тэгснээр 55 тэрбум ам.доллар Оросын эдийн засагт орж ирж, эргэлдэнэ гэж үзсэн байгаа юм. Улмаар оффшор бүсэд мөнгөө хадгалуулсан, ерөөсөө татвараас зугатааж, орлогоо нуусан иргэддээ өршөөл үзүүлэх хуулийн төсөл ч оруулсан. Ингэхдээ захиргааны болоод хуулийн хариуцлага хүлээлгэхгүй байх, ОХУ-ын банкуудад тусгай журам бүхий дансууд нээх зэрэг мөнгөө оффшор бүсэд хадгалж байгаа бизнесмэнүүдэд ашигтай олон заалт оруулсан. Гэх мэтээр асуудлыг шийдэх гээд л ажиллаж байгаа. Бид яагаад энэ жишгийг дагаж болохгүй гэж. Ямар нэг аргаар гадаадын татваргүй бүсэд байгаа мөнгөө татаж оруулж ирье л дээ. Манайх гадаадад байгаад тав байна уу, 10 байна уу хамаагүй тэр олон тэрбум ам.доллараа дотоодынхоо зах зээлд оруулаад ирвэл эерэг үр дүн авчрах нь мэдээж. “Шинэчлэлийн”, “Шийдлийн” Засгийн газрын үед Путины энэ ажлаас санаа аваад хийж чадаагүй. Хүчрээгүй юм байлгүй дээ. Тэгвэл одоо яагаад эхэлж болохгүй гэж. Оройтоогүй шүү дээ. Оффшор бүсэд мөнгөө хадгалуулна гэдэг бол тийм ч бузар булай юм биш л дээ. Бизнесмэнүүд арай гэж хэдэн төгрөгийн ашиг олдог. Тэрийг нь татвар нэрээр төр хуу хамаад авчихдаг. Улмаар хэдэн дарга нар нь хувьдаа завшаад дуусгачихдаг манайх шиг оронд бизнес хийдэг хүмүүс мөнгөө найдвартай газар хадгалаад, жаахан өсгөөд авахыг бодно биз дээ. Тэр байдлыг нь буруутгах аргагүй.

Гэхдээ Монголоос оффшор бүсэд мөнгөө хадгалж байгаа нөхдүүдийн цөөнгүй хувь нь төрийн томоохон албан тушаалтнууд байгаад бас учир бий. Тэд бизнес хийж олсон мөнгөө нуусан уу. Эсвэл хээл хахуулиар олж авсан мөнгөө гадагш гаргав уу гэдгийг бодолцож үзвэл байдал хэцүүхэн болчих гээд байгаа юм. Гэхдээ л аль ч хувилбар нь байсан манайхан мөнгөө буцааж оруулж ирэх арга замыг хайх л хэрэгтэй байна. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат энэ тал дээр жаахан ажиллаад өгөөсэй. За тэр идэж, уусан мөнгөө энд тэнд аваачаад нуусан нөхдүүдийг оролдохоо больё. Бизнесмэнүүдээ өршөөлд хамруулаад, татвар талаас нь дэмжээд, ядаж Орос шиг бодлого бариад мөнгийг нь оруулж ирэх талаас нь ажилламаар л байна даа. Нээрээ энд дахиад нэг зүйл сануулъя. Хэрвээ улстөрчид нь авлигад авсан мөнгөө гадаадад аваачаад нуусан байдаг бол хоорондоо тохиолцоод, улсдаа бага хүүтэй, уртхан хугацаатай зээлэх хувилбар ч бас байгаа шүү дээ. Дээр дурьдсан, жаахан бодож үзнэ биз, эрхэм эх орончид.

Дугаарын 60 мөр

## Хөдөөний замд шалгалтаа хийгээч

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэгвэл гэнэт явуулсан энэхүү шалгалтад жолооч нарын дийлэнх нь бүдэрч байгаа нь мэдээж. Учир нь манайхан автомашинд заавал байх ёстой галын хор, ослын тэмдэг, эмийн санд тэр бүр ач холбогдол өгөөд байдаггүй, хэнэггүй нь дэндсэн хүмүүс болохоор шалгалтад бүдрэх нь лавтай. Түүгээр ч барахгүй энэхүү шалгалтыг улсын төсөвт дөрвөн тэрбум төгрөг хуримтлуулахаар явуулсан гэх мэдээлэл цацагдсан. Харин үүнийг албан хүн нь “Энэ бол гэнэт хийж байгаа ажил биш. Жолооч нараас мөнгө салгах гээд байгаа ч юм биш. Тиймээс ташаа мэдээлэл гэдгийг хэлэх нь зүйтэй. Замын цагдаагийн газраас урьд өмнө ч нэгдсэн болон хэсэгчилсэн байдлаар ийм хяналт, шалгалт явуулж байсан. Бүтэн жилийн төлөвлөгөөнд тусгасан ажлын нэг нь эдгээр өдөр болж байна. Түүнээс биш ямар нэг улс төрийн захиалгаар энэ ажлыг хийгээгүй” хэмээн тайлбарлаж байна. Хуульд зааснаар бол эдгээр гурван зүйлийг авч яваагүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахыг хориглодог. Харин бодит байдал дээр манай жолооч нар сануулга авч, зарим нь торгуулж аваад замын цагдаагаас мултардаг нь үнэн. Жолооч нар ч аюулгүй байдлыг хангахдаа зөвхөн замын цагдаагийн албан хаагчийн нүдийг хуурах төдийхнөөр хандаж байгаа нь өөрсдийгөө эрсдэлд оруулж байгаа хэрэг. Тиймээс нэг нь шалгаж сүрийг үзүүлж, нөгөө нь торгуулж байж ухаан ордгоос хойш яая гэх вэ. Ямар ч л байсан, “Хяналт шалгалт” гэх сүржин нэртэй шалгалт хийгддэгээрээ хийгдэж, галын хор, ослын тэмдэг, эмийн сан зардаг хүмүүс баяжиж байгаа нь үнэн. Тэгэхдээ энд нэг зүйл хэлэхэд, хяналт шалгалтыг зөвхөн нийслэлийн хэмжээнд л хийгээд байгаа бололтой. Саяхан орон нутгаас Улаанбаатар хот руу ирэх замд бүрэн бус тээврийн хэрэгсэл маш их зөрж байгаа нь хяналт шалгалтыг нийслэлийн хэмжээнд хийж байгааг батлах шиг. Үнэндээ 22-ын товчоо руу дөхөх тусам нэг гэрэл нь байхгүй, холын гэрэл нь асдаггүй олон машинтай таарлаа. Дээрээс нь манайхан холын замд гэрлээ шилжүүлж мэддэггүйгээс гадна утааг бол жинхэнэ утгаар нь “үйлдвэрлэж” байна билээ. Гэтэл өнөөх хяналт шалгалт нь тэнд байгаа ч үгүй. Улсын хэмжээнд явж буй автомашинуудыг бүгдийг нь шалгана гээд байсан хэрнээ утаа үйлдвэрлэсэн, бүрэн бус автомашинуудыг зүгээр л хот руугаа нэвтрүүлж байна. Хяналт шалгалтыг ингэж өнгөцхөн хийж, нэг хэсгийг нь торгож, арга хэмжээ аваад ч яах юм бэ. Түүний оронд орон нутаг дахь постоо нэмэгдүүлж, хот руу орж ирдэг товчоон дээрээ хяналт шалгалтаа сайн хиймээр юм. Ер нь бол бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн жолооч, зорчигчдын эрүүл мэнд, амь нас өөрийнх нь гарт байгаа гэдгийг ухамсарлах л учиртай. Замын цагдаа нар ч ялгаагүй, улсын хэмжээнд хяналт шалгалт явуулна гэсэн бол түүнийгээ хэрэгжүүлэх л хэрэгтэй байна. Ялангуяа хөдөөгийн замд, өөрсдийн чинь хайгаад байгаа нөхдүүд олон байна шүү гэдгийг дуулгачихъя.

УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

# М.ИЧИННОРОВ: ТӨРИЙН ЦАГДАА ХОХИРОГЧИЙН ӨМГӨӨЛӨГЧИЙН БАЙР СУУРИНД АЖИЛЛАХ ЁСТОЙ

–Энэ бол хэн нэгний имиж, чимэг болоод явах ёстой асуудал биш–



**Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт**

Тэдэнд хэдэн тэр бумаар үнэлэгдэх их мөнгийг цацаж гарч ирсэн, бас хань хамсаатнуудаа төрийн өндөр албадад томилуулахаар наймаалцсан наймааныхаа тухай л өдөр шөнөгүй бодохоос өөр сэтгэл чилээх асуудал байдаггүй юм шиг л санагдах юм.

**-Саяхан гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг хөндсөн эрэн сурвалжлах сэтгүүлзүйн нэвтрүүлэг Ийгл ТВ-ээр гарч олон хүнд хүрлээ. Үүнээс харахад, УИХ-ын гишүүд энэ хуулийг уншиж үзээгүй байж хүчингүй болгосон байдлыг илчилсэн. Та энэ талаар юу гэж бодож байна?**

-Эрэгтэй гишүүд бүү хэл эмэгтэй гишүүд нь ч энэ миний мэдэх ёстой асуудал биш, энэнээс ч асуу, тэрнээс ч асуу, энэ миний имиж биш, тэрний имиж гэх мэт ичгүүртэй зүйлс ярьж сууна билээ. Ийм юмаар имиж хийнэ гэж байдаггүй юм. Хэн нэгний имиж чимэг болоод явдаг ч асуудал биш. Энэ бол хүний эрх, эрх чөлөөний асуудал, хүний амь нас, эрүүл мэнд, бүрэн бүтэн байдлын тухай ноцтой асуудал, нийгмийн маш хурц бөгөөд эмзэг асуудал юм. Ийм улс төрчидтэй хатуу хариуцлага тооцож чаддаг иргэний нийгмийн, олон нийтийн гал цогтой тэмцэл үгүйлэгдэж байгааг илтгэж байна. Хуулиа уншиж үзээгүй байж энэ хэрэггүй гэж буцаадаг, хойшлуулдаг ямар гээч улс төрийн соёл вэ. Өөрөөр хэлбэл, яасан бүдүүлэг, соёлгүй, замбараагүй байдал вэ гэж асуумаар байна.

**-Есдүгээр сарын 1-нээс энэ хууль болон бусад багц хуулиуд хэрэгжээд эхэлсэн бол хоёр ч эмэгтэйн алтан амийг аварч болох байлаа хэмээн олон нийт, мэргэжлийн хүмүүс үзэж халагдаж байна. Энэ талаар та юу хэлэх вэ?**

-Тиймээ, үнэхээр харамсалтай зүйл боллоо. Зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль төдийгүй Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль Прокурорын тухай хууль, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд хамтдаа хэрэгжиж, Монгол төр иргэдээ хүчирхийлэлээс хамгаалдаг, төр өөрөө хохирогчийн өмгөөлөгч, хамгаалагчийн байр сууринд байж чадах байлаа. Наад үйлдлээс чинь олон хүний нус нулимс, зовлон тарчлаан үнэртэж байна шүү гэж бид эрх баричгдад сануулж байсан. Үнэхээр л энэ батлагдаж байна.

**-Эрх баригчид ГБХ-ийн тухай хуулийг сайжруулаад дахин өргөн барина гэж хэлсэн. Энэ хэр боломжтой вэ?**

-Гэр бүлийн хүчирхийлэлтэй ганц шалдан хуулиар тэмцэж болдоггүй гэдгийг бид өнгөрсөн арван жил өчнөөн зовлон тарчлаан, нулимс үхэл хагацлаар харлаа. Тиймээс хуульчид, өөрөөр хэлбэл шүүгч, прокурор, цагдаа, мөрдөн байцаагч, бүгд хэрэглэж болдог хуулийг АН-ын засаглалын үед хийсэн. Цагдаа, шүүхийнхэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцдэг ганц хуулиар хүнийг хамгаалж чаддаггүй байсан. Хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо нь хуульчдын хэрэглэдэг бусад хамаатай хуулиудтай холбогдох тодорхой заалтууд байдаггүй байсантай энэ бол холбоотой л доо. Тэгэхээр энэ хуулийг дангаар нь УИХ-д өргөн бариад сайжруулаад оруулж ирнэ гэж байгаа нь үнэндээ бол заль. Олон нийтийн эсэргүүцлээс айсан хэрэг. Нөгөөтэйгүүр энэ бол сайн алхам угаасаа биш. Хууран мэхэлсэн, дүр эсгэсэн үйлдэл.

**-Гэрч, хохирогчийг хамгаалах Тахарын албыг татан буулгалаа. Та Гэрч, хохирогчийг хамгаалах газрын даргаар ажиллаж байсны хувиар энэ тал дээр юу гэж бодож байна вэ?**

-Манайд Тахарын албыг хэт хожуу байгуулсан. АНУ-ын Маршалын алба гэж алба байдаг, тэр нь зохион байгуулалттай, мафийн, цагаан захтнуудын зэрэг хүнд төрлийн гэмт хэргийн гэрчийг хамгаалалтанд авч, сэжигтэн, яллагдагчийг хуяглан хүргэх болон оргон зайлсан сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах үүрэгтэй байгууллага л даа. Харин хохирогчийг цагдаагийн газар болон холбооны мөрдөх товчоо хамгаалалтандаа авч бүх төрлийн туслалцаа дэмжлэг үзүүлэн төрийн нэрийн өмнөөс тэдний өмгөөлөгчийн байр сууринаас ханддаг. Гэтэл манайд гэрч, хохирогчийг хамгаалах функцийг хоюуланг нь Тахарын албанд өгсөн. Уул шугамандаа бол хохирогчийг цагдаа хамгаалах ёстой юм байгаа юм. Гэхдээ шинэ институцийн хувьд Тахарын алба дээр хөрөнгө мөнгө ч сайтай байсан, хохирогч хамгаалалын бүтцийг хийж, хүмүүсээ сургаж бэлтгэсэн байсан. Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийг хэрхэн яаж хэрэглэхийг хууль сахиулагчдад, шүүгч, прокуроруудад анхнаасаа сурталчлан зааварчилж өгөөгүй дутагдал оршиж байсан. Одоо нэгэнт гэрч, хохирогчийг хамгаалах функцийг цагдаад шилжүүлж өгч байгаа тул бие бүрэлдэхүүнийг маш сайн сургаж, цэнэглэж, хохирогчтой харилцах сэтгэлгээ, арга барилын хувьд ихээхэн дэвшил авчрах хэрэгтэй. Энэ үйлсэд биднийг зөвлөхөөр оролцуулж болно шүү дээ. Төрийн цагдаа бол хохирогчийн өмгөөлөгчийн байр сууринд ажиллах ёстой юм шүү дээ.

**-Саяхан болсон жирэмсэн эмэгтэй гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь насаа алдсан хэргийн талаар олон нийт санаа зовниж, энэ хэрэг бас л шударга бусаар шийдэгдэх байх гэж хардаж байгаа?**

-Үнэхээр тийм шүү. Нэг ч гэсэн хүний амь насны асуудалд буруутгагдахгүйн тулд эрх баригчид хэргийн бүрдүүлэлтийг хуурамчаар үйлдүүлж, арьсаа хамгаалах даалгавар өгсөн байх гэж би хардаж байна. Орон дээрээсээ өөрөө унаад гэмтээд үхчихсэн ухааны юм бүрдүүлэх бололтой. Бүтэн долоон жил хүчирхийлэлд байсан гэж хөршүүд нь ярьсан байна лээ. Зөрчлийн тухай хуулиар туслалцаа үзүүлж, мэдээлэл өгөх иргэд, байгууллагуудын хариуцлагыг хуульчилсан байсан. Мөн эрүүгийн байцаан шийтгэх хууль болон хууль сахиулагчдын эрх зүйн байдлын тухай хуулиар гэр бүлийн хүчирхийллийн дуудлагад нэн даруй хариу үйлдэл үзүүлэх, шаардлагатай тохиолдолд тухайн айлын хаалгыг нь хүртэл эвдээд орох эрх нээгдэж байсан юм. Эүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хохирогчийг айлгах замаар өргөдөл татаж авдаг байдлыг таслан зогсоох заалтууд орсон байсан. Тун харамсалтай юм боллоо.

**-Шинээр шорон барина, их зардал гарна, сургалт хийгдээгүй гэх шалтгаар эрх баригчид зөрчлийн хууль, эрүүгийн хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхээс татгалзаж, хойшлуулсан?**

-Нэгэнт батлагдсан хуулийг хойшлуулах, буцаах, хүчингүй болгох Үндсэн хуулийн бус бусармаг алхмуудыг хийж байна. Үүнийг би цэвэр улс төрийн шалтгаантай гэж бодож байна. Ирэх жил болох ерөнхийлөгчийн сонгуульд зэрлэг, бүдүүлэг, хатуу догшин эрүүгийн эрх зүйн орчинтойгоо орохыг хүсч байгаа байдал юм. Угтаа бол ялын бодлого хүмүүнлэг, энэрэнгүй, засан хүмүүжүүлэх, үр дүнтэй, эдийн засгийн хэмнэлттэй, зөв тогтолцоо руу шилжиж байсан юм. Шорон нэмэх нь бүү хэл харин ч шоронгийн тоо хасагдах байсан.

**-Эдгээр болон нийгмийн бусад эмзэг асуудалд хамгийн сонор соргог, тууштай хандах ёстой байсан эмэгтэй гишүүд нь намынхаа бодлогыг барин, аялдан дагалдах байр суурьтай байна гэж олон нийт зэвүүцэж байна?**

Тийм шүү. Үнэхээр нэлээд олон эмэгтэй гишүүдтэй болсон. Гэтэл, асуудал тоондоо гэхээсээ чанартаа байдаг юм байна гэж бодогдоход хүрч байна. Эмэгтэйчүүдийг улс төрд гаргана, тоог нь нэмнэ, тэгснээр нийгмийн байдал сайжирна гээд маш олон сая ам.долларын төслүүд төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгуулагуудын дунд хэрэгждэг. Улс төрд ялгаагүй л хэн их мөнгө төлнө тэр нь бялуугаа хуваах зарчим эмэгтэйчүүдийн хувьд ч хэрэгждэг бол зөв, мэргэшсэн, сайн эмэгтэй улс төрчид гарч ирэх боломжгүй. Нийгмийнхээ салбар бүрийн манлайлагч эмэгтэйчүүдийг дэмжин улс төрд гаргаж ирэх бодлого, стратеги үгүйлэгдэж байна. Гэхдээ, түрүүчийн парламентад эмэгтэй гишүүд маань санаа нэгтэйгээр эдгээр нийгмийн эмзэг асуудлуудад хандаж, сайн ажилласныг бид сайшаадаг. Тухайн улс төрийн намын соёл нь нөлөөлдөг юм байна гэдгийг ч бас харууллаа.



**Сенсаацийн эргэн тойронд**

# БАРИВЧИЛГАА, ШАЛГАЛТ ҮРГЭЛЖИЛСЭЭР...

АТГ болон хууль хяналтын байгууллагуудаас авлига, хээл хахуулийн хэрэгт холбогдуулан нэлээд олон хүнийг баривчилж, заримыг нь шалгаж эхлээд байна. Тухайлбал, УИХ-ын гишүүн асан, Эдийн засгийн хөгжлийн сайд асан Н.Батбаярыг энэ сарын 15-наас эхлэн “Чингис”, “Самурай” бондын зарцуулалтын асуудлаар шалгаж эхэлсэн бол “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Комерийн дэд захирал асан Т.Батчулуун зарим хүмүүстэй хуйвалдан, их хэмжээний мөнгө угаасан хэрэгт сэжиглэгдэн, саатуулагдаад байна. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаагийн “Онцлох хуудас”-аараа дээрх баривчилгааны эргэн тойрон дахь асуудлыг онцоллоо.

### МИАТ-ИЙН ЗАРИМ УДИРДЛАГЫГ БАРИВЧИЛЖЭЭ

**2016.09.25:** “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Комерийн дэд захирал асан Т.Батчулуун нь найз н.Баясгалан болон ХБНГУ дахь “МИАТ” ТӨХК-ийн төлөөлөгчийн газрын дарга н.Доржсэрэм нартай хуйвалдан, их хэмжээний мөнгө угаасан хэрэгт сэжиглэн, саатуулжээ. Т.Батчулуун, н.Доржсэрэм, н.Баясгалан нар нь онгоцны зорчигчдын үйлчилгээнд хэрэглэгдэх бараа бүтээгдэхүүн нийлүүлэх тендерт ХБНГУ-ын “Schneider Co ltd..” гэх хуурамч компанийг шалгаруулж, “МИАТ” ТӨХК-д гурван еврогийн үнэтэй дарсыг таван евро нэмэн найман евро болгох зэргээр үнийг нь өсгөн бараа бүтээгдэхүүнийг шахаж борлуулан их хэмжээний орлого олсон байжээ. Эх сурвалжийн мэдээлснээр үнэтэй бараа “МИАТ” ТӨХК-д шахан борлуулж, олсон их хэмжээний орлогын мөнгөө н.Баясгалан нь Монгол Улс руу иргэн О, А нарын данс руу шилжүүлдэг байсан байна. Улмаар “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Комерийн дэд захирал асан Т.Батчулуун, ХБНГУ дахь “МИАТ” ТӨХК-ийн төлөөлөгчийн газрын дарга н.Доржсэрэм нар нь тухайн иргэдээс 1.5 тэрбум гаруй төгрөгийг банкнаас гаргуулан авах үедээ үйлдэл дээрээ цагдаагийнханд баривчлагдсан тухай эх сурвалж мэдээллээ.

### 200 САЯЫН ХАХУУЛЬ АВСАН Н.БАТСҮХИЙГ СААТУУЛАВ

**2016.07.18:** Нийслэлийн Баянзүрх дүүргийн Өмч, газрын харилцааны албаны дарга Н.Батсүх долдугаар сарын 10-ны өдөр БНХАУ-ын иргэн Л-ээс 200 гаруй сая төгрөгийн хахууль авсан нь тогтоогджээ. Түүнийг БНХАУ-ын иргэнд хууль бусаар газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож байхад нь Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн алба хаагчид үйлдэл дээр нь барьж, саатуулсан талаар ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвөөс мэдээллээ. Дээрх мөнгө нь хятадуудтай тохиролцсон хууль бус үйлдлийг хаацайлах гэсэн урьдчилгаа төлбөр байсан бололтой. Н.Батсүх нь уг хэргийг үйлдэхдээ өөрийн удирдлага дор ажилладаг, иргэн Б, Ч, П нартай үгсэн тохиролцож, иргэдийн цахим үнэмлэхийг ашигласан байжээ. Мөн БНХАУ-ын иргэн Л-д Баянзүрх дүүргийн Их цуурайтын аманд 42 айлын газар эзэмших гэрчилгээ олгосон нь тогтоогдсон байна. Авлига өгсөн Ли овогт Хятад иргэн нь Монголд барилгын салбарт 10 орчим жил үйл ажиллагаа явуулж буй барилгын компанийн захирал юм байна. Цагдаагийн алба хаагчид нотлох баримтыг хураан авч, Эрүүгийн хуулийн 268-д заасан зүйл заалтаар буюу Н.Батсүх нарыг хээл хахууль авсан гэж буруутган, АТГ-тай хамтран эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлжээ. Хэрэв Н.Батсүх нар шүүхийн байгууллагаар буруутай нь тогтоогдвол 5-10 жилийн хорих ялаар шийтгэгдэх юм.



### УИХ-ЫН ГИШҮҮН АСАН Н.БАТБАЯРЫГ АТГ-ААС ШАЛГАЖ ЭХЭЛЖЭЭ

**2016.09.21:** УИХ-ын гишүүн асан, Эдийн засгийн хөгжлийн сайд асан Н.Батбаярыг энэ сарын 15-наас эхлэн АТГ-аас шалгаж эхэлжээ. Түүнийг “Чингис”, “Самурай” бондын зарцуулалтын асуудлаар шалгаж байгаа аж. Тодруулбал, дээрх бондуудын мөнгийг зарцуулахдаа эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 264 дүгээр зүйлийн 264.2, 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар сэжигтнээр тооцон шалгаж байгаа аж. Н.Батбаяр нь 2012-2014 онд Эдийн засгийн хөгжлийн сайдаар ажиллаж байхдаа “Чингис”, “Самурай” бондуудын нийт 2.1 тэрбум ам.долларын захиран зарцуулалтыг хариуцаж байсан юм. Ингэхдээ бондуудын мөнгөөр “Гудамж төсөл”, “Гэр хорооллын дахин төлөвлөлт” болон 888 төсөл хөтөлбөрүүд зэрэг олон төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт хийсэн гэдэг. Гэхдээ бондын захиран зарцуулалтын тодорхой мэдээлэл өнөөдрийг хүртэл нууцлагдмал явж ирсэн билээ. Мөн “Чингис”, “Самурай” зэрэг бондын хөрөнгийг хувиарладаг байсан Хөгжлийн банкны удирдлагуудыг ч мөн АТГ-аас шалгаж байгаа юм.

### ТӨРИЙН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ОРЛОГЧ Т.ДОРЖДЭРЭМИЙГ АТГ-ААС СААТУУЛЛАА

**2016.09.09:** Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс Төрийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч Т.Дорждэрэмийг хээл хахуулийн хэрэгт сэжиглэн, энэ сарын 09-ний өдөр баривчилжээ. Т.Дорждэрэмийг Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлд заасанчлан хахууль авсан, эрх мэдлээ урвуулан ашигласан, банкны хууль тогтоомж зөрчсөн гэх үндэслэлээр сэжигтнээр тооцон, цагдан хорих захирамжийг шүүгч гаргасан тухай эх сурвалж мэдээлсэн. Түүнийг Төрийн банкны гүйцэтгэх захирлын орлогч хэмээх албан тушаалаа ашиглан их хэмжээний найдваргүй зээл бусдад олгосон, ингэхдээ бусдаас хахууль авсан гэж буруутгасан байна. Мөн удахгүй Т.Дорждэрэм улсад хэдий хэмжээний хохирол учруулсан нь аудитын болон шинжээчдийн дүгнэлтээр тодорхой болох аж.

### НӨХГ-ЫН ГАЗРЫН ДАРГА Б.АМАРЖАРГАЛЫГ БАРИВЧИЛЖЭЭ

**2016.09.15:** Нийслэлийн Өмчийн харилцааны газарт /хуучин бүтцээр/ Удирдлага бодлого төлөвлөлтийн газрын даргаар ажиллаж байсан Б.Амаржаргал нарыг Авлигатай тэмцэх газар энэ сарын 14-нд баривчлан саатуулсан тухай эх сурвалж мэдээллээ. Б.Амаржаргалыг бусдаас их хэмжээний хахууль авсан хэрэгт буруутган, сэжигтнээр татсан байна. Мөн Баянгол, Сүхбаатар дүүргийн Өмч, газрын харилцааны албадын дарга нарыг ч саатуулаад байгаа юм. Сүхбаатар, Баянгол дүүргийн Өмч, газрын харилцаа, НӨХГ гэхчилэн газрын албаныхан ийнхүү хуулийн байгууллагынхны анхаарлыг татаж эхэллээ. Бусдаас мөнгө авч, хууль бусаар газар эзэмшүүлж, өмчлүүлсэн хэрэгт холбогдох хүний тоо цаашид нэмэгдэх магадлалтайг эх сурвалж хэлсэн бол Налайх дүүргийн Өмч, газрын харилцааны албаныхан ч хуулийн байгууллагын анхааралд байгаа тухай мэдээлэл байна. Тодруулбал, өнгөрсөн долдугаар сарын 29-ний өдөр Баянгол дүүргийн Өмч, газрын харилцааны албаны дарга С.Бямбадорж, Сүхбаатар дүүргийн Өмч, газрын харилцааны албаны дарга Т.Мөнхбаатар нарыг бусдаас их хэмжээний хээл, хахууль авсан хэрэгт буруутган, АТГ-аас баривчилж, хорих 461 дүгээр ангид хорьсон. Сүхбаатар дүүргийн Өмч, газрын харилцааны албаны дарга Т.Мөнхбаатарыг тус дүүргийн 20 дугаар хороо, Бэлх зуслангийн Хадатын аманд байрлалтай “Хадат Вилла” хотхоныг барьж буй компанид 40 айлын газрын бичиг баримтыг хуурамчаар үйлдэн өгч, оронд нь олон тэрбум төгрөг авсан авлигын хэрэгт сэжиглэн саатуулсан юм. Харин Баянгол дүүргийн Өмч, газрын харилцааны албаны дарга С.Бямбадоржийг иргэдэд олгогдох ёстой 0.07 га газрыг нь дээрэмдэн авч, газрын захирамжийг хуурамчаар үйлдэж бусдаас их хэмжээний мөнгө авсан хэрэгт буруутгажээ.

**Сэтгүүлчийн өнцөг**

# БАРИВЧИЛЖ БОЛНО, ХАРИН ХЭЛМЭГДҮҮЛЭВ ЭЭ

Н.ПУНЦАГБОЛД

...Шууд баривчилж хорьчихоод, дараа нь та буруугүй юм байна гээд, уучлал ч гуйхгүй явуулдаг тохиолдол зөндөө л бий...

Сонгуулийн өмнө болон дараа баахан баривчилгаа явагдаж, албан тушаалтан, төрийн албан хаагчдыг барьж хорьдог, шалгадаг, шүүдэг байдал уламжлал болоод удаж байна. Энэ удаагийн сонгуулийн дараа ч гэсэн давтагдлаа. Долдугаар сараас авахуулаад л зарим нэг хүнийг барьж, хорьсон. Шалгаж байгаа хүний тоо бол угаасаа олон байгаа. Ер нь бол төрийн албан хаагчдыг шалгаж, үнэхээр хууль зөрчсөн, мөнгө төгрөг шамшигдуулсан, хахууль авсан бол баривчлах нь зөв өө. Улс хямраад л байдаг, хурган ч болов дарга хийсэн хүмүүс нь баяжаад, нийгмээс тасраад алга болчихоод байгаа. Тийм болохоор цаг үргэлж шалгаж, хууль зөрчсөн бол хариуцлагыг нь тооцуулж, улсад үзүүлсэн хохирлыг нь төлүүлж байх ёстой юм. Энэ ажлыг заавал сонгуулийн өмнө, хойно хийгээд байх ч ёсгүй. Монгол шиг албан тушаалтнууд нь авлигад идэгдчихсэн, ялзарсан, хээл хахууль тэнгэрт тулчихсан оронд үүн шиг хэрэгтэй юм алга. Харамсалтай нь энэ ажлыг зөв хийчих удирдагч манайд алга. Бүгд л хээл хахууль аваад, хөлжөөд, баяжаад дууссан. Дур нь хүрвэл “жижиг загас”-нуудаа дэгээдэж байна.

Дээрх дугуй дотор хэн хэнийг сонгуулийн хойно баривчилсныг уншигч авхай та харж байгаа байх. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Өмч, газрын харилцааны албаны дарга ч гэнэ үү нэг жижиг нөхөр. Гэхдээ мань хүн жижиг гэлтгүй 200 сая төгрөгийн хэрэгтэй л холбогдчихоод байгаа юм. Мөн Төрийн банкны гүйцэтгэх захирлын орогч гээд бас нэг “жараахай” тууж явсан. Хуучнаар Нийслэлийн өмчийн харилцааны газрын нэг жижиг даргын нэр ч тууж яваа. Арай том нь УИХ-ын гишүүн, сайд асан Н.Батбаяр. Гэхдээ түүнийг ердөө л шалгаж байгаа. Баривчилсан хүмүүсийн дунд бол МИАТ-ийн дэд захирал асан Т.Батчулуун гэдэг нөхрийн нэр дурьдагдсан.

Энэ нөхөр 1.5 тэрбум төгрөг банкнаас гаргаж авах гэж байгаад үйлдэл дээрээ баривчлагдсан хэмээн мэдээллийн хэрэгслүүд мэдээлж байна. Ийм л хэрэг ар араасаа цуварч байгаа. Энэ мэт үйлдэл дээрээ баригдсан нөхдүүд ч яахав. Хэргийг нь сайтар шалгаад, хохирол байгаа бол төлүүлээд явах хэрэгтэй. Баривчилж болно. Үнэхээр хэрэг хийгээд, хахууль авчихсан баривчлах л ёстой. Харин хэлмэгдүүлж болохгүй. Нэг хүнийг заавал харлуулж, муухай харагдуулах гэж зүтгэж, давхар баахан хүн хэлмэгдүүлдэг, хорьдог тохиолдол манайд бишгүй л гарсан. Янз бүрийн жишээ татаж болно. Шууд баривчилж хорьчихоод, дараа нь та буруугүй юм байна гээд, уучлал ч гуйхгүй явуулдаг тохиолдол зөндөө л бий. Хамгийн сүүлд Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийг муухай харагдуулах гэж “Нүүрс” хөтөлбөртэй холбож хэдэн хүнийг янз бүр болголоо. Энэ хөтөлбөрийн нягтлан бодогчоор ажиллаж байсан нэг эмэгтэй шүүх хурал дээр Монголын шүүх, прокурорынхныг нүдний булай болгоо биз дээ. Дараа нь түүнийг буруугүй гээд сулласан. Өнөөх эмэгтэй нь Монголын төрөөс хохирлоо нэхэмжлээд явж байна. Мэдлэгтэй, чадвартай хүмүүс ингээд л хохирлоо нэхэмжлээд, зарим нь бүр ялалт байгуулаад, мөнгөө гаргуулаад авчихаж байгаа. Ийм л алдааг төр, хууль хяналтынхан битгий гаргаасай билээ. Түүнээс биш татвар төлөгчдийн мөнгөнөөс хумслаад, тэрбумаар нь хадгалаад, нааш цааш нь болгоод байгаа нөхдүүдийг барьж хорих л хэрэгтэй.

## ДЭЛХИЙ



# ХОЙД СОЛОНГОС ЗЭВСГИЙН ХҮЧЭЭ ХАРУУЛАВ



Б.ДАВААХҮҮ

Тав дахь удаагаа цөмийн зэвсэг туршч, бүс нутгийнхнаа айдас хүйдэст автуулаад буй БНАСАУ өнгөрөгч бямба гарагт агаарын шоуг зохион байгуулжээ. Шоу нь тус улсын түүхэн дэх анхны олон нийтийн хамарсан үйл ажиллагаа байсан бөгөөд цэргийнхэн болоод энгийн иргэд ч олноороо хүрэлцэн ирж сонирхсон байна. Хоёр өдрийн турш үргэлжилсэн үйл ажиллагаа тус улсын зүүн этгээд дэх Вонсан боомт хотод зохион байгуулагджээ. “Вонсаны олон улсын нөхөрлөлийн агаарын фестиваль” нэртэй уг үйл ажиллагааг бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор өнгөрсөн жил засварын ажлыг нь гүйцэтгэн дуусгажээ. Мөн өмнө нь цэргийн нисэх онгоцны зогсоол байсан Калмагийн нисэх буудлыг Восан Калма олон улсын нисэх онгоцны буудал болгон өөрчилсөн байна. Тус улсад нисэх онгоцны буудал байх хэдий ч, цэргийнхний байнгын хяналтад байдаг аж.

Харин энэ удаагийн үйл ажиллагааг тохиолдуулан нисэх буудлын ойролцоох зам, барилга байгууламжийг нээлттэй ажиллуулснаар орон нутгийн худалдаа эрхлэгчид, гадны хэвлэл мэдээллийн ажилтнууд, мөн дэлхийн 20 гаруй орноос агаарын шоу үзүүлбэрийг үзэхээр 15 гаруй мянган хүн цугларсан байжээ. Шоуг БНАСАУ есдүгээр сарын 9-нд цөмийн зэвсэг туршихаас өмнө төлөвлөсөн байв. Гэвч цөмийн туршилт хийсэнтэй холбогдуулан олон улсын нийгэмлэг хатуу шүүмжилж, улмаар угийн ганцаардмал улсын эсрэг хэд хэдэн хориг арга хэмжээ тавигдаж болзошгүй болсон. Үүнээс өмнө дөрөв дэх цөмийн зэвсгээ туршсаны дараа НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн баталсан тогтоолоор БНАСАУ-ын нисэх хүчний салбарт хориг тавьсан байдаг. Гэвч Пхеньян энэ удаагийн агаарын шоундаа АНУ-ын “Hughes” компанид үйлдвэрлэсэн MD500 загварын байлдааны нисдэг тэрэгний үзүүлбэрээр шоуг нээжээ. Уг нисдэг тэрэг нь Хойд солонгос улс гуравдагч орноор дамжуулан 1980 онд АНУ-аас авсан техникүүдийн нэг нь аж. Түүнчлэн, тус улсын агаарын шоунд MiG29 байлдааны онгоцны хамгийн анхны загвар багтаж байсан бөгөөд дангаараа акробат нислэг үйлдэн гайхалтай үзүүлбэрийг сонирхуулсан байна.

> ...цөмийн туршилт хийсэнтэй холбогдуулан олон улсын нийгэмлэг хатуу шүүмжилж, улмаар угийн ганцаардмал улсын эсрэг хэд хэдэн хориг арга хэмжээ тавигдаж болзошгүй болсон...

Шоунд нийтдээ 20 гаруй байлдааны онгоц оролцсоноос ихэнхи нь эдүгээ хуучирсанд тооцогдох MiG17, MiG 19, MiG21 загварын БНХАУ-д үйлдвэрлэгдсэн онгоцууд байжээ. Улмаар шоуг үзэж сонирхсон салбарын мэргэжилтнүүд Пхеньяны агаарын цэргийн зэвсгийн хүчийг БНСУ-тай харьцуулахад харьцангуй сул дорой гэх дүгнэлтийг хийсэн байна. Түүнчлэн, энэ удаагийн арга хэмжээнд залуу удирдагч Ким Жон Ун тэргүүтэй Засгийн газрынтөлөөлөгчидоролцоогүй гэнэ. Үүнээс гадна Аюулгүйн зөвлөлийн шийдвэрийн дагуу хориглогдсон онгоцонд хэрэглэгдэх шатахууныг Хятадаас авсан байж болзошгүй гэх таамгийг ч шинжээчид дэвшүүлжээ. Ямартай ч, тав дахь удаагаа цөмийн зэвсэг туршсантай холбогдуулан улс орон бүр тус улсын эсрэг авсан хориг арга хэмжээгээ чангатгаж буй энэ үед Пхеньян агаарын шоу үзүүлбэр зохион байгуулсан нь хоригийг үл тоож буйг илтгэж байна хэмээн зарим эх сурвалж онцолсон байв.

## Тед Круз Трампыг дэмжинэ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг тодруулах Бүгд найрамдах нам доторх сунгаанд үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамптай ширүүхэн өрсөлдөж явсан сенатч Тед Круз сонгуульд хэнийг дэмжихээ ний нуугүй илэрхийлжээ. Техас мужийн сенатч тэрбээр Ерөнхийлөгчийн сонгуульд нам нэгтнээ дэмжих гэнэ. Бүгд найрамдах нам доторх сунгаанд тэдний хооронд ширүүн тэмцэл өрнөж байсан удаатай. Хоёр нэр дэвшигч нэг нэгийгээ даван гарахын тулд сошиал сүлжээгээр хүртэл хэрүүлийн үг унагаад амжсан байдаг. Сонгуулийн тулаанаас нэрээ татаж, сайн дураараа Доналд Трампт бууж өгсөн Тед Круз долдугаар сард болсон Бүгд найрамдах намын их хурал дээр “Өөрийнхөөрөө саналаа өгнө” хэмээж, Трампыг дэмжих бодолгүй байгаагаа ч илэрхийлж байв. Тэгвэл саяхан Тек Круз фэйсбүүк хуудастаа “Хэдэн сарын турш ажиглаж, залбирч өөрөө өөрөөсөө асуусны дүнд Ерөнхийлөгчийн сонгууль болох тэр өдөр Бүгд найрамдах намаас нэр дэвшиж буй Доналд Трампад саналаа өгөхөөр шийдлээ” гэж бичжээ. Мөн “Нэг жилийн өмнө би Бүгд найрамдах намын нэр дэвшигчээ дэмжинэ гэдгээ амлаж байсан. Тэр ч амлалтдаа хүрнэ. Хэрэв та бүхэн АН-аас нэр дэвшигч Хиллари Клинтоныг Ерөнхийлөгч болгохыг хүсэхгүй байгаа бол Доналд Трампыг сонгоорой” хэмээсэн байв.

## В.Путин Думын даргад ойрын хүнээ зүтгүүлэв

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин энэ сарын 18-ны өдөр болсон Төрийн Думын сонгуулийн ялагчид нэгэнтээ тодорсны дараа намын төлөөллүүдийг хүлээн авч уулзжээ. Улмаар шинээр бүрэлдсэн Думын даргаар Ерөнхийлөгчийн тамгын газарт ажиллаж байсан туршлагатай өөрийн ойрын хүн болох Алексей Бородинг томилох санал гаргажээ. Энэ нь жилийн дараа болох Ерөнхийлөгчийн сонгуульд өөрийн байр сууриа баттай болгох эхний алхам хэмээн зарим эх сурвалж хардаж байна. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин эрх баригч Нэгдсэн Орос нам ялалт байгуулсан Төрийн Думын сонгуулийн дүнг хүлээн авсан юм. Улмаар Нэгдсэн орос нам болон Бүгд Найрамдах нам зэрэг улстөрийн хүчнүүдийн төлөөллийг хүлээн авч уулзан Думын даргад Алексей Бородинг дэвшүүлжээ. Энэ үеэр тэрбээр “Бородин депатутын хувиар ажлын туршлага ихтэй. Бүхий л нам эвсэл, депатуттай тулж харилцах чадвар сайтай” хэмээн магтаж, дэмжихийг уриалсан аж.



## “Galaxy note 2” утаснаас утаа гарчээ

Энэтхэгийн агаарийн тээврийн IndiGo компанийн зорчигч тээврийн онгоцонд зорчиж явсан нэгэн зорчигчийн Самсунг маркийн гар утаснаас учир битүүлэг утаа гарч зорчигчдыг сандаргажээ. Ухаалаг гар утасны салбартаа тэргүүлэгч БНСУ-ын Самсунг компанийн шинэ загварын гар утасны баттерей худалдаанд гарсан даруйд асуудал дагуулах болсон бөгөөд тус компани зах зээлээс 2.5 сая гар утсаа эгүүлэн татаад байгаа юм. Тэгвэл Энэтхэгийн авиа компанийн мэдээлснээр Сингапураас Энэтхэгийн Ченнай хотыг чиглэн нисч явсан 6E-054 нислэгийн дугаартай зорчигч тээврийн онгоцонд сууж явсан нэгэн үйлчлүүлэгчийн гар тээшнээс утаа гарчээ. Улмаар шалгахад “Galaxy note 2” маркийн гар утаснаас бага хэмжээний утаа гарч байсан гэнэ. Энэ явдалд сандарсан зорчигч галын хор цацсаныхаа дараа ухаалаг утсаа усанд дүрж аюулгүй болгожээ. Ингэсний дүнд онгоц төлөвлөгөөний дагуу зорьсон газартаа ямар нэг саатлалгүй хүрч чадсан аж. Ямартай ч, энэ удаагийн явдлаар Самсунгийн зөвхөн Galaxy note 7 ч бус, бусад төрлийн утасны аюулгүй байдлыг шалгахад гэмгүй болох нь тогтоогдсон байна.

## Бан Ги Мүн хандив гуйжээ

2015 онд хүчирхийлэл болон зэвсэгт мөргөлдөөний улмаас дэлхий дахинд 13.6 их наяд долларын хохирол амсчээ хэмээн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн мэдэгджээ. Тэрбээр НҮБ-ын Энхийг тогтоох санг дэмжих асуудлаарх бага хуралд оролцож үг хэлэхдээ “Уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн хямрал, залуучуудын ажилгүйдэл зэрэг нь хүмүүст асар их дарамт учруулж байна. Хэдийгээр дайн тулаан улс орнуудын дотоодод болж байгаа боловч түүнд гадны хүчнүүд, төрийн бус байгууллагууд хөндлөнгөөс оролцож байна. Хүчирхийлэл, зэвсэгт мөргөлдөөний улмаас 2015 онд дэлхий дахинд 13.6 их наяд долларын хохирол учирсныг долоон тэрбум хүнд хуваахад нэг хүнд 1.8 мянган ам.доллар ногдож байна. Зэвсэгт мөргөлдөөний улмаас зовж зүдэрч буй дүрвэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, энхийг сахиулах үйл ажиллагаа явуулахад зөвхөн 2015 онд гэхэд 34 тэрбум ам.доллар зарцуулсан” гэжээ. Хүмүүнлэгийн үйлст цаг алдалгүйгээр мөнгө хөрөнгө зарцуулснаар олон эмгэнэлт хэрэг явдал гарахаас урьдчилан сэргийлж болно гэдгийг тэрбээр цохон тэмдэглээд НҮБ-ын Энхийг тогтоох санд хандив өргөхийг уриалсан байна.

## Холливудын киног хориглолоо

Болливудын киног шүтэж, эсрэгээр АНУ-ын Холливудын киног гаргахыг хориглосоноор тав дахь удаагаа цөмийн зэвсэг туршин бүс нутгийнхнаа айлгаад амжсан Пхеняны олон улсын кино наадам хаалтаа хийжээ. Пхеньяны кино наадам анх 1987 онд зохион байгуулагдаж байсан бол 1990 оноос жил бүр зохиогдох болжээ. Харин 2000 оноос Их Британи, Францын кинонууд тус наадамд өрсөлдөх болсноор хүрээ нь улам өргөжих болж, Канн, Берлиний кино наадмуудтай эн тэнцэхүйц дэлхийн хэмжээний үйл ажиллагаа болж чаджээ. Гэхдээ наадамд оролцох киног хэрхэн сонгодог нь одоогоор тодорхой бус бөгөөд шүүлтийг олон улсаас уригдан ирсэн кино урлагийнхан бус “Korea Film Export and Import Corp” хариуцдаг гэнэ. Тус байгууллагын гүйцэтгэх захирал Ким Жа Хёк кино наадамд энх тайван, сайн санааг тусгасан бүтээлийг оролцуулах бөгөөд аль нэг улсыг гутаан доромжилж шүүмжилсэн киног оролцуулахгүй гэжээ. Ингэснээр БНСУ болон АНУ-ын кино Пхеньяны олон улсын кино наадамд оролцох эрхгүй болсон байна. Мөн тус улсад гаргахыг хориглосон аж. Пхеньяны наадамд 20 гаруй улсын 60 гаруй бүтээл оролцжээ. Улмаар гран приг өнчин хүүхдийг тэтгэж буй эмэгтэйн тухай БНАСАУын “The Story of our Home” хүртсэн байна.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл


# ШУУРХАЙ МЭДЭЭ

## ЗАЛУУС НОМОО СОЛИЛЦОНГОО ХОТОО ЦЭВЭРЛЭНЭ

Н.ЗАЯА

*Нэг үеэ бодвол залуус хаа тааралдсан газраа хог хаях нь багасч байгаа. Гэхдээ л соёлгүй хотын иргэн олон байгаагаас гудамж талбайн хог багсахгүй л байна. Тиймээс номонд хорхойтой хэсэг залуус нийтийн хог цэвэрлэх ажлыг зохион байгуулахаар болсон байна. Энэ талаар "Номтой оюуны ирээдүй" төрийн бус байгууллагын гишүүн Б.Энхтуяагаас тодрууллаа.*

**-Танай клуб байгуулагдаад хэр удаж байгаа юм бэ. "Номтой өглөө" клуб ямар үйл ажиллагаа явуулдаг талаараа тодруулаач?**

-Анх ном уншиж, уншсан номныхоо талаар ярилцах, бие биенээсээ суралцан өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлээр манай клуб нэгдэж байлаа. "Номтой өглөө" клуб маань хоёр жилийн хугацаанд уулзалтаа долоо хоногт 2-3 удаа тогтмол явуулж ирсэн. Гэхдээ үйл ажиллагаагаа илүү нийгэм, олон нийтэд хүргэх үүднээс энэ сард "Номтой оюуны ирээдүй" хэмээх нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага байгуулаад байна. Ер нь Монгол улсын хөгжил Монгол хүний хөгжлөөс эхэлнэ гэдэг биз дээ. Тиймээс бидний үйл ажиллагаа Монгол улсын хөгжлийн төлөөх ажил гэж ойлгож болно.

**-Танай клуб олон нийтийн хог цэвэрлэх ажлыг зохион байгуулах гэж байгаа гэсэн үү?**

...“Тархины хогийг цэвэрлэе” хэмээх уриатай олон нийтийн хог цэвэрлэх арга хэмжээ маань ирэх аравдугаар сарны 01-ний бямба гарагт зохион байгуулагдах болно. Энэхүү үйл ажиллагааг “Номтой Оюуны Ирээдүй” НҮТББ-г дэмжиж ХААИС, “Samsung корпораци”, “АПУ” ХХК, Гэрэл зурагчдын баг зэрэг байгууллагууд нийгмийг соён гэгээрүүлэх үйлсэд хамтран ажиллаж байгаа юм...

-Манайх байгууллагынхаа олон нийтийг хамарсан анхны өргөн хүрээний ажил болох "Тархины хогийг цэвэрлэе" хэмээх уриатай олон нийтийн хог цэвэрлэх ажлыг зохион байгуулах гэж байна. Уг ажлын хүрээнд Сүхбаатар дүүрэгт байрлах 15 км үргэлжилсэн газрыг буюу та бидний сайн мэдэх Сэлбэ голын эрэг дагуух газрыг цэвэрлэхээр төлөвлөмөн. Энэхүү нийгэмд хандсан ажилд "ХААИС"-ийн 1000-1500 оюутан хамтран оролцоно. Нийслэл хотоо өнгө үзэмжтэй байлгах хүсэл эрмэлзлийг дэмжиж буй хэнч нэгдэж болно.

**-Хог цэвэрлэх ажлын хажуугаар өөр үйл ажиллагаа болох уу?**

-Тэгэлгүй яахав. Уг арга хэмжээнд оролцох хүмүүс дурын нэг номтойгоо ирнэ. Үүгээрээ тэд зүгээр нэг удаа хог цэвэрлээд өнгөрөх бус хүмүүсийг хог хаях бүдүүлэг үйлдлийг эсэргүүцэж, нийслэлийн соёлч иргэн болох, ном уншиж, уншсан номоо ухаж ойлгох соёлд суралцах, улмаар тархиндаа хог тарихгүй, байгаль дэлхийгээ хайрлахад суралцахыг уриалан дуудаж байгаа далд агуулгатай юм. Мөн өөр хоорондоо номоо солилцох боломжийг олгож байгаагаараа онцлогтой.

**-Энэхүү үйл ажиллагаа яг хэзээ болох юм бэ. Мэдээж хамтран ажиллаж байгаа байгууллагууд байгаа байх?**

-"Тархины хогийг цэвэрлэе" хэмээх уриатай олон нийтийн хог цэвэрлэх арга хэмжээ маань ирэх аравдугаар сарны 01-ний бямба гарагт зохион байгуулагдах болно. Энэхүү үйл ажиллагааг "Номтой Оюуны Ирээдүй" НҮТББ-г дэмжин ажиллаж байна. Харин ХААИС, "Samsung корпораци", "АПУ" ХХК, Гэрэл зурагчдын баг зэрэг байгууллагууд нийгмийг соён гэгээрүүлэх үйлсэд хамтран оролцож байгаа.

PHOTO NEWS







Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

*Бразилийн Рио де Жанейро хотноо болсон паралимпийн XV наадамд амжилттай оролцсон манай улсын баг тамирчид өнгөрсөн бямба гарагт эх орондоо хүрэлцэн ирлээ. Риогийн паралимпд манай улсаас найман тамирчин багт буудлага, хөнгөн атлетик, хүчний гурван төрөл, байт харвааны төрөлд оролцсон юм. Паралимпийн зуны наадмаас Пауэрлифтингийн 88 кг-ийн жинд Э.Содномпилжээ, жүдо бөхийн 60 кг-ийн барилдаанд Б.Ууганхүү нар тус тус хүрэл медаль хүртэж Монголчуудаа баярлуулсан билээ.*

## Усанд автсан 16 иргэний амь насыг аварчээ

Улаанбаатар хотын баруун чиглэл өнгөрсөн амралтын өдөр Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны орчим их хэмжээний бороо орсны улмаас усанд автсан 14 дуудлага ирсэн байна. Дуудлагын дагуу тус дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 25 албан хаагч шуурхай арга хэмжээ авч усанд автсан 12 иргэний амь насыг аварчээ. Тодруулбал, Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны Тахилтын эцэс Канад хаус хорооллын зүүн урд талын жалганд үерийн усанд урсаж байсан автомашинаас дөрвөн иргэнийг гаргаж, амь насыг нь аварчээ. Мөн тус хорооны Тахилтын эцэс дуудлагаар очиход уг айлын гэр, байшин нь үерийн усанд өртөж, 10 см орчим лаг шавар, хогонд дарагдан 50 метр орчим банзан хашаа нь жалганд эвдэрсэн байсныг гаргаж өгчээ. Тус хорооны Тахилтын нэгдүгээр буудал төмөр замын нүхэн гарцын хойд талд автомашинтай хүмүүс машинтайгаа усанд автсан дуудлагаар очиж, машинд байсан хоёр том хүн, гурван хүүхдийг аварсан байна. Түүнчлэн Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, Тахилтын эцэст автомашин үерт автлаа гэсэн дуудлагын дагуу Аврах ангийнхан очиход "Elantra" загварын автомашинд 43 настай эмэгтэй, зургаан настай хүү, 14, 10 настай охид байжээ. Тэднийг гарган аюулгүй газар хүргэжээ.

## Малчдын биед тууралт гарч эхэлсэн гэв

"Орхон голыг хамгаалах хөдөлгөөн"-өөс Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг дэмжлэг үзүүлэхийг хүсчээ. Энэхүү хүсэлтдээ "Орхон голын өнөөгийн бохирдол, экологийн сүйрэл"-ийг онцлон бичсэн байгаа юм. Орхон голын сав газар буюу голын эхэн дээр компаниуд алт олборлолт явуулж байгаа юм. Олборлолт нь газрын хэвлийг хөндийлж, усны урсац, бохирдолд нөлөөлж байна. Улмаар олборлолт явуулж эхэлснээс хойш Орхон гол бохирдож, хүн мал ундаалахын эцэсгүй боллоо. Өнөөдөр Орхон голоос ундны усаа авч байгаа нутгийн иргэдийн бие дээр салхин цэцэг шиг тууралт гарч, эмнэлэгт үзүүлэхээр онош нь тодрохгүй байна. Түүнчлэн хүүхдүүдийн гэдэс маш ихээр өвчилж байна. Орхон гол таван аймгийн 134 сум, багийн нутгаар дамжин тэтгэж, Сэлэнгэ голд цутгадаг учраас энэ нь үндэсний хэмжээний бөгөөд төрийн эрх баригчдын хэмжээнд шийдвэрлэх ёстой асуудал юм. Нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх, бохирдлоос шалтгаалаад байгаль орчинд учирсан хохирлыг тооцуулах, гэм буруутай этгээдүүдээр нөхөн төлүүлэх үүргүүдийг холбогдох газруудад өгсөн ч бодит байдалд хууль хэрэгжихгүй байгаа нь ноцтой зөрчил. Усны нөөц эрс багасахад алтны олборлогчид дур мэдэн ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах, томоохон гол мөрнүүдийг хаягдлаар булж бохирдуулах зэрэг хүний хүчин зүйл нөлөөлж байна гэдгээ тэд дээрх хүсэлтэд онцолжээ.

## Хариуцлага алдсан эмч нарт ял оноолоо

Нийслэлийн Баянгол дүүргийн прокурорын газраас яллах дүнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсний дагуу Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2016 оны энэ сарын 13-ны өдөр Шастины нэрэмжит нэгдсэн гуравдугаар эмнэлгийн нэр бүхий зургаан эмчид ял оноожээ. Тодруулбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэгт зааснаар нэг жил эмчлэх эрхийг нь хасах, нэг жил хорих ял оногдуулсан байна. Түүнчлэн ялыг Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан 2015 оны 08 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан "Өршөөл үзүүлэх тухай" хуульд хамруулан хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Хэргийн талаар тодруулбал, шүүгдэгч Н, Б, Э, Д, Н, Ө нар нь эмчийн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс эмчлүүлэгч Э нь өнгөрсөн оны нэгдүгээр сарын 07-ны өдөр нас барсан юм. Мөрдөн байцаалтын явцад Н, Б, Э, Д, Н, Ө нар нь өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй байдал нь өвчтнийг үхэлд хүргэх шалтгаан болох нь тогтоогдсон байна.

## Бүртгэлгүй 56 нэрийн эм илрүүлжээ

МХЕГ-аас эм, биобэлдмэлийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг энэ сарын 12-16-ны өдрүүдэд улсын хэмжээнд хийжээ. Шалгалтад 207 эмийн сан, 40 эм ханган нийлүүлэх байгууллага, хоёр эмнэлэг нийт 247 байгууллага аж ахуйн нэгжийг хамруулсан байна. Энэ хяналт шалгалт нь хуурамч, улсын бүртгэлд бүртгэгдээгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй, лабораторийн шинжилгээний үзүүлэлтээс бусад үзүүлэлтээр чанар, стандартын шаардлага хангаагүй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх арга хэмжээ авах зорилготой ажээ. Урьдчилан сэргийлэх хяналтын явцад хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 24 нэрийн 581 ширхэг, эмийн бүртгэлд бүртгэгдээгүй 56 нэрийн 3.524 ширхэг, хаяг шошгын зөрчилтэй 43 нэрийн 1.137 ширхэг эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг илрүүлжээ. Үүнээс нэг асуудлыг ЭЦГ-т шилжүүлж, нийт 124 нэрийн эм бүтээгдэхүүнд улсын байцаагчийн 26 акт үйлдэн хураан авч, иргэдэд чиглэсэн 15 сэрэмжлүүлэг, зөвлөгөө мэдээлэл түгээж ажилласан байна.


ХААН БАНК

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Сонгон шалгаруулалт зарласан огноо: 2016.09.14

**ДОХИОЛОЛ ХАМГААЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЖ, СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАН ХАМТРАН АЖИЛЛАХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ**

ХААН Банкны орон нутгийн салбар нэгжид ашиглагдах дохиоллын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж, суурилуулах, дохиоллын системийн үйл ажиллагааг 24 цагийн турш хянах мэдээ дамжуулах гэрээт компанийг сонгон шалгаруулах тул энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай байгууллага, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй байгууллагууд ХААН Банкны 5000004506000035 тоот дансанд 50,000 төгрөгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй тушааж, баримтыг оролцох хүсэлтийн албан бичгийн хамт Төв ХААН Банкны ресепшинд өгч, сонгон шалгаруулалтын өгөгдлийг авна уу.

Материалыг 2016 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цаг хүртэл Төв ХААН Банкны ресепшин хүлээн авах ба зөвхөн шалгарсан компани, аж ахуйн нэгжид бичгээр хариу мэдэгдэнэ.

**Хаяг:** Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүлийн гудамж-25, ш/х-192 Улаанбаатар 14250

Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг procurement2016@khanbank.com хаягт хандаж авна уу.

Харилцагчийн хөдөлгөөний төв **1800-1917** www.**khanbank**.com khanbank.com/**facebook** khanbank.com/**twitter**


СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮС НУТГААР ЦОЧИР ХҮЙТЭРНЭ

Цаг уурын байгууллагын ирүүлсэн мэдээллээр газар тариалангийн бүс нутгаар энэ сарын 23-26-ны өдрүүдэд хур тунадас, хугацааны эцсээр нойтон цас орж, цасан шуурга шууран агаарын температур өмнөх хоногуудаас 8-13 хэмээр буурч, шөнөдөө хөрсөн дээр -0 ..-5 хэм хүрч цочир хүйтрэх төлөвтэй байгаа ажээ. Цаг агаарын цочир хүйтрэлтэй холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газраас төв, орон нутгийн Онцгой байдлын анги байгууллагын хүрээнд ард иргэдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах үүрэг, чиглэлийг өгчээ. Ургац хураалтын ажилд оролцож буй нийт иргэд, малчид, хадланч, тариаланчиддаа анхааруулахад цочир хүйтрэл, нойтон цас орох үеэр өөрсдийн аюулгүй байдал, бэлэн байдлаа хангах, үр тариа, ил задгай төмс, хүнсний ногоо хайрагдах, цасанд дарагдахаас урьдчилан сэргийлэх, авто замд халтиргаа үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг анхааруулж байна. Мөн хөдөө орон нутагт цаг агаарын цочир хүйтрэлийн үеэр малчид малаа ойрын бэлчээрт бэлчээх, бага насны хүүхдийг малд явуулахгүй байх, бага насны хүүхдэд тавих хараа хяналтаа дээшлүүлэхийг анхааруулаа.

## Визний хугацаа хэтрүүлсэн иргэдэд өршөөл үзүүлж байна

БНСУ-д сард дунджаар 360 монгол иргэн визний хугацаагаа хэтрүүлэн үлдэж байгаа талаар мэдэгдсэн. Тэгвэл БНСУ-ын Цагаачлалын албанаас визний хугацаа хэтрүүлэн хууль бусаар оршин суугаа гадаадын иргэдийг сайн дураараа нутаг буцахад нь өршөөл үзүүлэх аяны хугацааг энэ оны арванхоёрдугаар сарын 31-н хүртэл сунгажээ. Ингэснээр визний хугацаагаа хэтрүүлэн оршин сууж буй гадаадын иргэд дээр дурдсан хугацаанд сайн дураараа нутаг буцах тохиолдолд БНСУ-д буцаж орох эрх нь нээлттэй болох юм.

NO STRESS

ДУУЛГАХ СОНИН

# “ДЭВШИЛТЭТ САВЛАГАА” номинацийн эзнээр “Berlin” брэнд тодорлоо





Э.ТУУЛ

Монголчууд бидний мах, махан бүтээгдэхүүн буюу хиамны хэрэгцээг 1946 оноос хойш хангаж, түүхт 70 жилийнхээ ойтой золгож буй “Мах комбинат” буюу эдүгээгийн бидний мэдэх “Мах импекс” ХК-ийн Хиам консервны үйлдвэр жил бүр хэрэглэгчиддээ шинэ бэлэг барьдаг билээ. Саяхан тус компанийнхан олон улсын стандартад нийцсэн савлагааны шинэ үйлдвэр буюу 2014 оноос төлөвлөн хэрэгжүүлж байгаа хиамыг жижиглэн савлах төслөө танилцуулж, цоо шинэ савлагаатай цоо шинэ хиамыг хэрэглэгчиддээ хүргэж эхэлсэн.

Тэгвэл энэхүү шинэ үйлдвэрээс мэндэлсэн анхны бүтээгдэхүүн болох “Berlin” брэндийн цуврал таван хиам “Намрын ногоон өдрүүд 2016” үзэсгэлэн яармагийн “Дэвшилтэт савлагаа” номинацийн эзнээр тодорчээ. ХХААХҮЯ-аас 11 дэх жилдээ зохион байгуулж буй үндэсний хэмжээний энэхүү томоохон үзэсгэлэнд хүнсний бүхий л үйлдвэр, аж ахуйн нэгжүүд хамрагдаж, хэрэглэгчдэд шинэ дэвшилтэт бүтээгдэхүүнээ танилцуулж худалдсан бөгөөд “Мах Импэкс” ХК-ийн “Berlin” брэндийн хэрчиж савласан таван төрлийн хиам хэрэглэгчдийн таашаалд хамгийн ихээр нийцсэний зэрэгцээ Монголдоо төдийгүй Ази тивдээ анхдагч технологи болж чаджээ. ХБНГУ-ын Мултивак болон Текстор компанийн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг суурилуулсны зэрэгцээ БНСУ-ын Бусонг болон SNSS компанийн хамт олон тусгай орчин бүрдүүлснээрээ онцлогтой юм.

Дашрамд сонирхуулахад, “Berlin” брэндийн бүтээгдэхүүн худалдаанд гарсан даруйдаа буюу есдүгээр сарын 12-нд МҮХАҮТ-аас зохион байгуулсан “Улаанбаатар түншлэл 2016” Олон улсын үзэсгэлэнгээс “Олон улсын стандарт нэвтрүүлэгч” шагналыг хүртсэн юм. Худалдаанд гарч, хэрэглэгчиддээ хүрсэн даруйдаа л ийнхүү үндэсний хэмжээний хоёр үзэсгэлэнгээс дараалан шагнал хүртсэн “Berlin” брэнд яалт ч үгүй монгол түмний хэрэглээ мөн юм.








Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -9
Шөнө -1

Нөгөөдөр
Өдөр -9
Шөнө -4

## Өдрийн зурхай

**Намрын дунд улаагчин тахиа сарын Найман цагаан мэнгэтэй Цагаагчин гахай өдөр. Сумъяа гараг**

**Үс засуулбал:**
Жаргал үргэлжид ирнэ
**Наран ургах, шингэх:**
06:50 - 18:46



*Өдрийн өнгө: Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, нялхасын хурим хийх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сэвтэй газар очих, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахайболой. Хол газар явахаар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.*

Бидэнд тохиолдсон

## ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Боогий



Эртээд найзынх руугаа орох гээд орцонд нь ороод лифт рүү нь очтол нэг охин зогсож байна. Намуухан дуу аялаад л. Ард нь хүн ирж байхад эргэж ч харахгүй. Тэгэхээр нь жаахан жийрхээд л ард нь зогсож байтал лифт ч ирлээ. Нөгөө охин лифт рүү ороод эргээд харсан чинь чёлктой үсээ задгай тавьчихсан, яг нөгөө япон солонгос аймшгийн кинон дээр гардаг сүнс. Би араас нь ороод л 6 дээр дарлаа. Ядаж байхад 6 нь ч юув дээ, 666 гэх зэргээр бодоод л зогслоо. Нөгөө охин кноп дээр дардаггүй ээ. Ард дуу аялаад л зогсоод байх юм. Би урд нь зогсчихсон, нуруу руу хүйт даагаад л. Ядаж байхад лифт нь ямар ч удаан явдаг юм. Тэгтэл ашгүй лифт онгойгоод л, би үсрээд л буулаа. Тэгээд найзыхаа хаалганы хонхыг дарсан чинь хаалгаа онгойлгодоггүй ээ. Тэгсэн мессэж ирж байна аа. “Мань нь найз охинтойгоо байна. Жаахан хүлээж бай” гээд л. Лифтэнд айчихсан гар чинь гэрэл бараадаад л, шатны наана зогсоод нилээд удаан хүлээгээд л байлаа. Тэгтэл дээрээс хүн ирж байна аа. Аймаар удаан, хөлийн чимээ тог тог гээд л, аяархан дуу аялаад л. Тэгсэн нөгөө охин гараад ирдэг юм. Би хөдөлж чадахгүй хөшөөд л зогсож байсан чинь ашгүй найзын хаалга онгойлоо. Гүйгээд л орчихлоо. Гэрт нь орчихоод найз охиноос нь санаа зовоод, орцонд айснаа хэлэхгүй байж байсан чинь “Мань найз охиноо гаргаж өгчихөөд ирье” гээд нөгөө хоёр гараад явчихлаа. Тэгсэн хонх дуугарлаа. Очоод хаалга нээсэн чинь нөгөө охин зогсож байдаг юм. Хаалгыг нь гялс хаагаад л хаалганаас холдчихсон. Дахиж хонх дуугарсангүй, чимээгүй байгаад л байлаа. Тэгсэн хонх дахиад л дуугарлаа. Очоод “Хэн бэ” гэсэн чинь манай найз “Би байна аа” гэж байна. Баярлаад л хаалга онгойлгосон чинь дахиад нөгөө охин зогсож байдаг байгаа. Хаалгаа тас хийтэл нь хаагаад л, гарт таарсан юмаараа зэвсэглэсэн чинь агааржуулагч таарчихаж. Тэгтэл түлхүүр дуугараад л, хаалга онгойлгоод нөгөө охин чинь ороод ирдэг байна шүү. За дуусаа, буг чөтгөр, Боогий ингээд bye боллоо гээд л бодсон чинь манай найз араас нь ороод ирдэг байна ш дээ. Тэгснээ “Эргүү юм чинь яагаад хаалгаа хаачихаж байгаа юм. Царай чинь яачихсан юм. Наад агааржуулагчаар яах гэж байгаа юм” гэснээ “Өө нээрээ танилц, манай хамаатны дүү. Энэ жил оюутан болж байгаа юм. Манайд байх юм” гэдэг байна шүү. Түүнийг нь сонсоод, бантаад баярлаад уйлах шахсан. Тэгсэн дүү нь чаавaас бас л гэртээ ирсэн чинь ах нь найз охинтойгоо байна гэхээр нь гэртээ орж чадахгүй орцонд хүлээгээд л гиюүрээд явж байсан юм билээ.

СОНИРХУУЛАХАД

## Х.Баярмаа ГОО САЙХНЫ НУУЦАА ХУВААЛЦАВ



Найруулагч Ц.Хүсэлбаатар, жүжигчин С.Өлзийхүү нарын авьяаслаг охин Х.Баярмаа гоо үзэсгэлэн, авьяас чадвараараа хэдийнэ олны танил болсон. Тэрбээр дэлхийн миссийн тэмцээнд эх орноо төлөөлөн оролцохын зэрэгцээ “Хүйтэн бороо” теле жүжиг, “Аюултай харилцаа”, “Галзуу зугаалга” зэрэг хэд хэдэн кинонд тоглож, өөрийн дүрийг мөнхлөөд амжсан азтай бас авьяаслаг бүсгүй. Тэгвэл залуухан жүжигчин бүсгүй өөрийн гоо сайхны нууцаа охид бүсгүйчүүддээ хуваалцжээ. Түүний гоо сайхан, сайхан биеийн нууц нь дасгал хөдөлгөөн гэнэ. Тэрбээр сайхан хөгжим сонсож, дасгал хөдөлгөөн хийдэг бөгөөд энэ нь гоо сайханд маш их тус дэм болдог гэж боддог аж. Мөн өглөө бүр ус ууж, орой унтахынхаа өмнө тараг уудаг зуршилтай гэнэ. Түүнчлэн оройн 18:00 цагаас хойш хүнд зүйл идэлгүй, ногоо ихэвчлэн хэрэглэдэг байна. Харин гоо сайхны бүтээгдэхүүний хувьд Япон улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг хэмээн өөрийн нууцаа охид бүсгүйчүүддээ дэлгэлээ. Дашрамд сонирхуулахад, авьяаслаг жүжигчин Х.Баярмаа боловсролдоо тун ч их анхаардаг байна. Тэрбээр одоо АНУ-ын Миссури мужийн Миссуригийн их сургуульд мэргэжлээрээ магистрт суралцаж байгаа ажээ.

ТЭНГИС КИНО ТЕАТР




Их сургуулийн нэг ангийн 7 найз ангийнхаа Мишээлийн төрсөн өдрийг тэмдэглэхээр аялалд гарна. Гэтэл Мишээлийн найз залуу үл мэдэгдэх шалтгаанаар Билгүүн зугаалгад явсангүй. Хүн бүхний төлөө санаа тавьж явдаг, ажилсаг, халамжтай ч охидын анхаарлыг татаж чаддаггүй Тайванаа найзуудаа хотоос зайдуу орхигдсон байшинд дагуулан иртэл тэнд залуусыг санаандгүй аюул хүлээж байжээ.




Өрөвтас шувууд хүүхэд авч ирж өгдөг хэмээн бэлэгшээдэг. Өрөвтаснууд шинэ хүргэлтийн үйлчилгээндээ шинэ технологи нэвтрүүлсэн нь бөөн асуудал болно.

